

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/04/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
АУДИТ

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

---

Товчилсон үгийн жагсаалт .....	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1Төлбөрийн акт .....	19
5.2 Албан шаардлага .....	20
5.3 Зөвлөмж .....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	22

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.04.22 № 01/42  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ТӨВ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Д.МАГВАНСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Шүүхийн 30 жилийн ой тохиолдсонтой холбогдуулан тогтвор суурьшилтай, идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан болон 2023 оны ажлын гүйцэтгэлээр хамт олноо хошуучлан, албан тушаалын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан албан хаагчдыг шагнахдаа цалингийн сангаас шагнасан байна.

**Аудитын гол асуудал**

Батлагдсан цалингийн зардлын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 9,182.7 мянган төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлэлгүй ахмадын санд төвлөрүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

G/Архив/Албан бичиг 2024/ А4

019000050

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,934,410.0	20,340,530.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,500,000.0	9,182,700.0
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,500,000.0	9,182,700.0
3121	Төгрөг	9,500,000.0	9,182,700.0
31211	Төрийн сангийн харилцах	9,500,000.0	9,182,700.0
35	БАРАА МАТЕРИАЛ	33,434,410.0	11,157,830.0
354	Хангамжийн материал	33,434,410.0	11,157,830.0
35410	Бичиг хэргийн материал	2,902,100.0	2,448,640.0
35420	Аж ахуйн материал	23,231,209.0	3,061,050.0
35430	Сэлбэг хэрэгсэл	156,870.0	0.0
35440	Түлш, шатах тослох материал	25,747.0	0.0
35470	Бусад хангамжийн материал	7,118,484.0	5,648,140.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	934,183,446.0	891,973,179.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	934,183,446.0	891,973,179.8
392	Биет хөрөнгө	844,083,446.0	801,451,513.2
39201	Барилга, байгууламж, орон сууц	651,025,922.6	651,025,922.6
39202	Хуримтлагдсан элэгдэл	-56,906,416.1	-75,765,022.0
39203	Авто-тээврийн хэрэгсэл	109,500,000.0	109,500,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-25,008,333.2	-43,158,333.2
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	266,744,399.5	302,872,679.5
39206	Хуримтлагдсан элэгдэл	-156,574,246.2	-194,943,099.3
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	154,722,435.1	171,458,955.1
39208	Хуримтлагдсан элэгдэл	-102,707,931.7	-121,377,997.7
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,924,674.2	6,924,674.2
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,173,518.1	-5,622,726.1
39217	Ном	536,460.0	536,460.0
393	Биет бус хөрөнгө	90,100,000.0	90,521,666.7
39301	Програм хангамж	2,050,000.0	2,490,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.0	-568,333.3
39303	Бусад биет бус хөрөнгө	88,600,000.0	88,600,000.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>977,117,856.0</b>	<b>912,313,709.8</b>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	977,117,856.0	912,313,709.8
51	Засгийн газрын хувь оролцоо	977,117,856.0	912,313,709.8
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	485,339,397.0	485,339,397.0
51101	Өмч: - төрийн	485,339,397.0	485,339,397.0
512	Хуримтлагдсан үр дүн	90,436,123.5	25,631,977.3
51210	Өмнөх үеийн үр дүн	-24,707,922.7	90,436,123.5
51220	Тайлант үеийн үр дүн	115,144,046.2	-64,804,146.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	401,342,335.5	401,342,335.5
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>977,117,856.0</b>	<b>912,313,709.8</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,068,729,173.0	2,601,738,100.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	154,903,473.0	51,032,900.0
120	Нийтлэг татварын бус орлого	154,903,473.0	51,032,900.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	136,903,473.0	51,032,900.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	136,903,473.0	51,032,900.0
120009	Бусад орлого	18,000,000.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,913,825,700.0	2,550,705,200.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,913,825,700.0	2,550,705,200.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,913,825,700.0	2,550,705,200.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,953,585,126.8	2,675,724,946.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,953,585,126.8	2,675,724,946.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,950,031,656.2	2,637,762,324.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,490,446,001.1	1,981,290,501.2
210101	Үндсэн цалин	1,039,195,703.0	1,233,318,114.4
210102	Нэмэгдэл	360,328,254.2	466,255,363.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,867,654.6	76,196,556.5
210104	Урамшуулал	47,054,389.2	205,520,466.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,614,999.4	251,382,033.2
210201	Тэтгэврийн даатгал	127,088,889.6	171,496,372.2
210202	Тэтгэмжийн даатгал	14,906,702.5	20,008,540.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,898,581.9	15,967,591.8
210204	Ажилгүйдлийн даатгал	2,974,620.5	3,991,447.8
210205	Эрүүл мэндийн даатгал	29,746,204.9	39,918,081.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,939,943.0	90,304,759.3
210301	Гэрэл, цахилгаан	7,441,597.2	10,245,360.7
210302	Түлш, халаалт	65,539,590.9	76,469,888.7
210303	Цэвэр, бохир ус	1,358,755.0	3,589,510.0
210304	Байрны түрээс	1,600,000.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	94,073,892.9	125,037,433.3
210401	Бичиг хэрэг	41,718,770.0	55,959,461.0
210402	Тээвэр, шатахуун	18,388,500.0	19,225,447.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,382,832.9	21,650,999.3
210404	Ном, хэвлэл	0.0	511,600.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	840,000.0	720,000.0

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,883,790.0	26,969,926.0
2105	Нормативт зардал	1,910,400.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,910,400.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,474,146.0	69,448,910.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	512,600.0	6,128,200.0
210604	Урсгал засвар	21,961,546.0	63,320,710.0
2107	Томилолт, зочны зардал	3,514,000.0	10,962,502.0
210701	Гадаад албан томилолт	0.0	176,000.0
210702	Дотоод албан томилолт	3,514,000.0	10,786,502.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,461,447.0	13,821,119.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,971,650.0	9,658,074.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.0	350,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,273,250.0	2,800,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,854.0	197,920.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.0	99,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.0	451,000.0
210807	Газрын төлбөр	212,693.0	265,125.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,596,826.8	95,515,066.2
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,596,826.8	95,515,066.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,553,470.6	37,962,622.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	34,996,556.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	23,396,556.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	11,600,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,553,470.6	2,966,066.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,553,470.6	2,966,066.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	115,144,046.2	-64,804,146.2
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	115,144,046.2	-64,804,146.2

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,923,325,700.0	2,559,887,900.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,500,000.0	9,182,700.0
120	Нийтлэг татварын бус орлого	9,500,000.0	9,182,700.0
120009	Бусад орлого	9,500,000.0	9,182,700.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,913,825,700.0	2,550,705,200.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,913,825,700.0	2,550,705,200.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,913,825,700.0	2,550,705,200.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,909,967,300.0	2,553,366,600.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,909,967,300.0	2,553,366,600.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,906,413,829.4	2,515,703,978.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,490,446,001.1	1,983,643,782.6
210101	Үндсэн цалин	1,039,195,703.0	1,224,135,414.4
210102	Нэмэгдэл	360,328,254.2	468,608,645.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,867,654.6	76,196,556.5
210104	Урамшуулал	47,054,389.2	214,703,166.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,614,999.4	249,028,751.8
210201	Тэтгэврийн даатгал	127,088,889.6	171,496,372.2
210202	Тэтгэмжийн даатгал	14,906,702.5	17,655,258.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,898,581.9	15,967,591.8
210204	Ажилгүйдлийн даатгал	2,974,620.5	3,991,447.8
210205	Эрүүл мэндийн даатгал	29,746,204.9	39,918,081.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,939,943.0	90,304,759.3
210301	Гэрэл, цахилгаан	7,441,597.2	10,664,360.7
210302	Түлш, халаалт	65,539,590.9	76,050,888.7
210303	Цэвэр, бохир ус	1,358,755.0	3,589,510.0
210304	Байрны түрээс	1,600,000.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	90,575,512.9	96,683,727.3
210401	Бичиг хэрэг	44,154,170.0	46,386,150.0
210402	Тээвэр, шатахуун	17,527,300.0	19,200,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,382,832.9	21,648,999.3
210404	Ном, хэвлэл	0.0	1,120,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	840,000.0	720,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,671,210.0	7,608,578.0
2105	Нормативт зардал	726,000.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	726,000.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,635,926.0	70,780,220.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,137,600.0	6,000,800.0

210602	Тавилга	0.0	4,160,000.0
210604	Урсгал засвар	29,498,326.0	60,619,420.0
2107	Томилолт, зочны зардал	3,514,000.0	11,766,400.0
210702	Дотоод албан томилолт	3,514,000.0	11,766,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,461,447.0	13,496,337.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,971,650.0	9,333,292.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.0	350,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,273,250.0	2,800,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,854.0	197,920.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.0	99,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.0	451,000.0
210807	Газрын төлбөр	212,693.0	265,125.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,500,000.0	0.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,500,000.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,553,470.6	37,662,622.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	34,696,556.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	23,396,556.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	11,300,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,553,470.6	2,966,066.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,553,470.6	2,966,066.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13,358,400.0	6,521,300.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,858,400.0	6,838,600.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,858,400.0	6,838,600.0
2200	Дотоод эх үүсвэрээр	3,858,400.0	6,838,600.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,858,400.0	6,838,600.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9,500,000.0	-317,300.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	9,500,000.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,500,000.0	9,182,700.0

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	485,339,397.0	402,657,005.5	(26,022,592.7)	861,973,809.8
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	485,339,397.0	402,657,005.5	(26,022,592.7)	861,973,809.8
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	115,144,046.2	115,144,046.2
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	485,339,397.0	401,342,335.5	90,436,123.5	977,117,856.0
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	485,339,397.0	401,342,335.5	90,436,123.5	977,117,856.0
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	485,339,397.0	401,342,335.5	90,436,123.5	977,117,856.0
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(64,804,146.2)	(64,804,146.2)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	485,339,397.0	401,342,335.5	25,631,977.3	912,313,709.8

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,550,705,200.00	2,547,739,134.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,550,705,200.00	2,547,739,134.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,525,471,500.00	2,522,542,578.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,982,971,400.00	1,983,643,782.61
210101	Үндсэн цалин	1,230,467,500.00	1,224,135,414.35
210102	Нэмэгдэл	503,557,900.00	468,608,645.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	74,157,600.00	76,196,556.51
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	252,454,000.00	249,028,751.80
210201	Тэтгэврийн даатгал	183,036,500.00	171,496,372.22
210202	Тэтгэмжийн даатгал	17,354,400.00	17,655,258.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,883,500.00	15,967,591.84
210204	Ажилгүйдлийн даатгал	3,470,900.00	3,991,447.79
210205	Эрүүл мэндийн даатгал	34,708,700.00	39,918,081.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,305,000.00	90,304,759.34
210301	Гэрэл, цахилгаан	11,400,000.00	10,664,360.70
210302	Түлш, халаалт	76,025,000.00	76,050,888.66
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	96,684,000.00	96,683,727.30
210401	Бичиг хэрэг	45,600,000.00	46,386,150.00
210402	Тээвэр, шатахуун	18,900,000.00	19,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,000,000.00	21,648,999.30
210404	Ном, хэвлэл	2,184,000.00	1,120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	720,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	42,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77,636,400.00	77,618,820.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00	11,999,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	60,636,400.00	60,619,420.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,598,700.00	13,496,337.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,347,200.00	9,333,292.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,800,000.00	2,800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	213,500.00	197,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	460,000.00	451,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	0.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	0.00	0.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,550,705,200.00	2,547,739,134.05
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,550,705,200.00	2,547,739,134.05
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	0	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	9500000
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	9182700

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газар нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэг бүхий Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа байгууллага юм.

2023 оныг “Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх” зорилго дэвшүүлэн 6 зорилт, 51 ажил, арга хэмжээг төлөвлөн ажилласан байна. Дэвшүүлсэн зорилго, зорилт, арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах
- Шүүхийн хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд хяналт тавих
- Шүүхэд ирүүлсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх
- Шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах
- Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээг авах
- Хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх, холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх
- Иргэн, хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, хариу өгөх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйл “Улсын дээд шүүх, түүний бүхэн эрх”, 85 дугаар зүйл “Шүүхийн тамгын газар”, мөн Төсвийн тухай хуулийн зарим зүйл заалт тухайлбал 8 дугаар зүйл “Төсвийн цагалбар”, 23 дугаар зүйл “Төсвийн орлого”, 24 дүгээр зүйл “Төсвийн зарлага”, 27 дугаар зүйл “Төсвийн төсөлд тавигдах шаардлага”-д өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Тус байгууллагын дотоод хяналт хариуцсан мэргэжилтэнгүй бөгөөд дотоод хяналт ажиллуулах дүрэм батлуулаагүй байна.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газар нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн хяналт шинжилгээ, дотоод аудитын хэлтэс гүйцэтгэдэг байна. 2023 онд тус байгууллагын үйл ажиллагаанд шүүхийн ерөнхий зөвлөлийн хяналт шинжилгээ, дотоод аудитын газраас аудит хийгээгүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг

нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020 оны 12 дугаар сарын 22 өдрийн №174 тушаалаар батласан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж байна Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 64,804.1 мянган төгрөгөөр буюу 6,6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,500.0	9,182.7	(317.3)
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	33,434.4	11,157.8	(22,276.6)
Үндсэн хөрөнгө	934,183.4	891,973.2	(42,210.3)
Нийт хөрөнгө	977,117.9	912,313.7	(64,804.1)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	977,117.9	912,313.7	(64,804.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	977,117.9	912,313.7	(64,804.1)

Бараа материал дансны хувьд 149,213.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 171,489.7 мянган төгрөгөөр буурахад аж ахуйн материал 20,170.2 мянган төгрөг, хангамжийн материал 1,470.3 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна. Энэ нь Богд хан уулын аймаг байгуулагдсаны 100 жил, Монгол Улсад шүүхийн байгууллага үүсэж байгуулагдсаны 30 жилийн ой тохиосонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд машин тоног төхөөрөмж 36,128.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 16,737.0 мянган төгрөг, программ хангамж 440.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд хөрөнгө хасагдаагүй байна. Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 5,559.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 840.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 440.0 мянган төгрөгийн программ хангамж худалдан авч, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 30,569.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 15,897.0 мянган төгрөгийн тавилгыг үнэ төлбөргүй хүлээлгэн өгч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,537,000,0 мянган төгрөг, нийт зарлагыг 2,537,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас үндсэн үйл ажиллагааны зардлыг 13,124.3 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 20,000.0 төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,550,324.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжихээр баталсан байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,550,324.3 мянган төгрөг буюу 100 хувь санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,550,158 мянган төгрөг буюу 99,8 хувьтай байгаа нь ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 166.3 мянган төгрөгөөр тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах-Үндсэн үйл ажиллагааны зардал	2,523,124.30	2,523,124.30	-	100.0
2	Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах-Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	1,800.00	1,800.00	-	100.0
3	Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	25,400.00	25,233.70	166.30	99.3
	Дүн	2,550,324.30	2,550,158.00	166.30	99.99

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газар нь 2023 онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

#### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70701 /Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах/-80101 /Үндсэн үйл ажиллагааны зардал	2023.01.01 2023.12.31	Шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийг хүний нөөцөөр хангах, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүхийн санхүү эдийн засгийн баталгааг хангах, нэмэлт ажил гэсэн 6 зорилт, 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	Шүүхийн хараат бус бие даасан байдлыг хангаж, шаардлагатай байгаа шүүгчийн туслах 3, архив бичиг хэргийн 1, нярвын 1 сул орон тоонд мэргэжлийн хүн авч ажиллуулсан байна. Хэрэгжилт 100 хувь	2,523,124.30	2,523,124.30
2	70701 /Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах/-80224 /Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	2023.01.01 2023.12.31	Шүүх хуралд иргэний төлөөллөөр оролцсон иргэдэд мөнгөн урамшуулал олгох	Шүүх хуралд иргэний төлөөллөөр томилогдон ажилласан иргэдэд 1.8 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна. Хэрэгжилт 100 хувь	1,800.00	1,800.00
3	70701 /Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах/-80802 /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2023.01.01 2023.12.31	Тэтгэвэрт гарах нэг албан хаагчид болон хөдөлмөрийн дотоод журамд тусгасан нөхцөлд олгох	Тэтгэвэрт гарсан 1 албан хаагчид 23.4 сая төгрөг, албан хаагчдын түлээ нүүрсний хөнгөлөлтөд 1.8 сая төгрөг олгосон байна. Хэрэгжилт 100 хувь	25,400.00	25,233.70
Дүн					2,550,324.30	2,550,324.30

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1 хөтөлбөр, 3 арга хэмжээг 99,9 хувьтай хийж гүйцэтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2023 онд төсвийн хөрөнгөөр бичиг хэргийн материал 46,544.1 мянган төгрөг, шатахуун 19,200.0 мянган төгрөг, багаж, техник хэрэгсэл 6,000.8 мянган төгрөг, тавилга 4,160.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 13,496.3 мянган төгрөгөөр худалдан авалт хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төрийн хэмнэлтийн тухай хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №01/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны үр дүнгийн тайлангийн орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн орлого 2,068,729.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 31,030.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага тэвчиж болох зардлыг хэмнэж ажиллах үүрэгтэй боловч Төв аймаг дахь Шүүхийн тамгын газар нь зарцуулагдаагүй үлдсэн цалингийн зардлаас албан хаагчдыг шагнасан, төсвийн хөрөнгөөр улсын байцаагчийн актаар тавьсан алдангийг төлсөн зөрчил илэрсэн.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2023 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийхэд байршуулах ёстой мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

2023 онд тус байгууллагын үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 13,018.8 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй зөрчилд зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 6 сарын 30-ны өдрийн №257 дугаарын албан бичгээр ирүүлсэн байна. 2023 оноос эхлэн төрийн сангийн программ нь гүйлгээг нэхэмжлэх эхэлж үүссэний дараа хийдэг болсон нь дээрх зөрчлийг багасгах үндэс болсон байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	13,018.8	1	13,018.8	100
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>					

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цалингийн зардлын гүйцэтгэл, бараа материалын бүртгэл, түүнд тавих хяналтын талаар авч үзэхээр шийдвэрлэсэн.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 214,194.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 214,194.9 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- Шүүх хуралд оролцсон иргэдийн төлөөлөгч нарт 707.2 мянган төгрөгийн урамшууллыг Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын ХААН банкны 5721512775 дугаарын дансаар дамжуулан кассаар олгосон ажил гүйлгээг арилжааны банкны харилцах данс болон кассын дансанд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Цалингийн урьдчилгаа 145,380.0 мянган төгрөгийг суутгаж хаахдаа цалингийн өглөг дансанд бүртгэлгүй зардал дансанд бүртгэж хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 8 ААН, иргэнээс худалдаж авсан 12,879.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогод аваагүй, 3 ААН-ээс худалдан авсан бараа материалын дүн нь шилжүүлсэн мөнгөн дүнгээс 2,569.8 мянган төгрөгийн илүү орлогод авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Түлш халаалт, цахилгааны зардал 43,476.1 мянган төгрөгийг бүртгэхдээ нэхэмжилсэн дүнгээр бүртгээгүй, улирлын дүнг бөөн дүнгээр нэг удаа бүртгэхдээ байгууллагад өгөх өглөгөөр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 30,374.5 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 9,362.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, 21,011.79 мянган албан шаардлага, зөвлөмж хүргүүлээ.

### 5.1 Төлбөрийн акт

Тамгын газрын даргын 2023 оны А/83 дугаар тушаалаар ажилчин, албан хаагчдад олгосон түлээ, нүүрсний хөнгөлөлтөөс 180.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй байна. Энэ Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Энэ хуулийн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсхүл төвлөрүүлээгүй бол” төлбөрийн акт тогтооно гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

Батлагдсан цалингийн зардлын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 9,182.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэлгүй ахмадын санд төвлөрүүлсэн байна. Энэ Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, МУЗГ-ын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3. Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана.” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсхүл төвлөрүүлээгүй бол” төлбөрийн акт тогтооно гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

## **5.2 Албан шаардлага**

Нийгмийн даатгалын байцаагчийн 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 84 дугаарын улсын байцаагчийн тавьсан актын алданги 335.6 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөр төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” бол албан шаардлага өгөх гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

Шүүхийн 30 жилийн ой тохиолдсонтой холбогдуулан тогтвор суурьшилтай, идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан болон 2023 оны ажлын гүйцэтгэлээр хамт олноо хошуучлан, албан тушаалын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан албан хаагчдыг 18,571.4 мянган төгрөгөөр шагнахдаа цалингийн сангаас шагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” бол албан шаардлага өгөх гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

Харилцагч байгууллага, иргэнтэй хийсэн худалдан авалтыг төлбөрийн цахим баримт, нэхэмжлэхийн дүнтэй тулгалт хийхэд 2,104.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Сангийн сайдын 347 дугаар тушаалын “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад

нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5-д "Төлбөрийн баримт" заалтыг болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" үүссэн бол албан шаардлага өгөх гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

### **5.3 Зөвлөмж**

#### **1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Төв аймаг дахь Шүүхийн тамгын газарт бүртгэлтэй HYUNDAI starex маркын 0623 ТӨА улсын дугаартай автомашины улсын дугаарыг ялгагдах өнгө бүхий дугаараар солиогүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ." гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх машины улсын дугаарыг ялгагдах өнгө бүхий дугаараар солих Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн сангийн харилцах данснаас ХААН банкны 5721512775 дугаарын дансанд шилжүүлсэн гүйлгээг арилжааны банкны харилцах данс болон касст бүртгээгүй	1	707.2			1	707.2	1	707.19
Цалингийн урьдчилгааг суутгаж хаахадаа цалингийн өглөг дансанд бүртгэлгүй зардал дансанд бүртгэж хаасан байна.	1	145,380.0			1	145,380.0	1	145,380.00
Тайлант онд 8 ААН, иргэнээс худалдаж авсан 12,879.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогод аваагүй байна.	1	12,879.1			1	12,879.1	1	12,879.14
3 ААН-ээс худалдан авсан бараа материалын дүн нь шилжүүлсэн мөнгөн дүнгээс 2,569.8 мянган төгрөгийн илүү орлогод авсан боловч өглөг дансанд үлдэгдэлгүй байна.	1	2,569.8			1	2,569.8	1	2,569.80
Түлш халаалт, цахилгааны зардлыг бүртгэхдээ нэхэмжилсэн дүнгээр бүртгээгүй, байгууллагад өгөх өглөгөөр бүртгэсэн, улирлын дүнг бөөн дүнгээр нэг удаа бүртгэсэн байна.	1	43,476.1			1	43,476.1	1	43,476.13
Санхүүгийн тайлангийн уялдааг шалгахад 9182.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Санхүүгийн тайлангийн тодруулга, толилуулгыг гаргаж ирүүлсэн	1	9,182.7			1	9,182.7	1	9,182.70
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>214,195.0</b>			<b>6</b>	<b>214,195.0</b>	<b>6</b>	<b>214,194.96</b>

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Харилцагч байгууллага, иргэнтэй хийсэн худалдан авалтыг төлбөрийн цахим баримт, нэхэмжлэхийн дүнтэй тулгалт зөрүүтэй байна.	1	2,104.8			1	2,104.80				
Тамгын газрын даргын 2023 оны А/83 дугаар тушаалаар ажилчин, албан хаагчдад олгосон түлээ, нүүрсний хөнгөлөлтөөс ХХОАТ суутгаагүй	1	180.0	1	180.0						
Батлагдсан цалингийн зардлын төсвөөс зарцуулагдаагүй үлдсэн үлдэгдлийг төвлөрүүлэлгүй ахмадын санд төвлөрүүлсэн.	1	9,182.7	1	9,182.7						
Нийгмийн даатгалын байцаагчийн 2023 оны 12 сарын 13-ны өдрийн 84 дугаарын улсын байцаагчийн тавьсан актын алдангийг төсвөөс төлсөн	1	335.6			1	335.63				
Шүүхийн 30 жилийн ой тохиолдсонтой холбогдуулан тогтвор суурьшилтай, идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан болон 2023 оны ажлын гүйцэтгэлээр хамт олноо хошуучлан, албан тушаалын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан албан хаагчдыг шагнахдаа цалингийн сангаас шагнасан байна.	1	18,571.4			1	18,571.36				
Төв аймаг дахь Шүүхийн тамгын газарт бүртгэлтэй HYUNDAI starex маркын 0623 ТӨА улсын дугаартай автомашины улсын дугаарыг ялгагдах өнгө бүхий дугаараар солиогүй байна	1						1			
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>30,374.5</b>	<b>2</b>	<b>9,362.7</b>	<b>3</b>	<b>21,011.79</b>	<b>1</b>			